

2017 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу хүлээгдлийн мэдээ ирүүлэх 12 байгууллагаас 2 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага мэдээ ирүүлсэн.

Нэг. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторын эмчийн үзлэгийн хүлээгдэл:

2017 оны 2 дугаар сард УХТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын эмчийн үзлэг хүлээгдэлтэй, харин мэдээ ирүүлсэн бусад эмнэлгүүд /УНТЭ, УГТЭ, ГССҮТ, СЭМҮТ/ хүлээгдэлгүй ажилласан байна. Тухайлбал:

ХСҮТ-ийн амбулаторын 9 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс хамгийн олон үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй кабинетийн тоонд хими эмчилгээ-/48 үйлчлүүлэгч/, элэг, цөс, нойр булчирхайн мэс засал-/46 үйлчлүүлэгч/, эмэгтэйчүүд судлал-/44 үйлчлүүлэгч/, цээжний хөндийн мэс заслын кабинет-/37 үйлчлүүлэгч/ тус тус орж байна. Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал, хөнгөвчлөх, хими эмчилгээний кабинетын хүлээгдэл өмнөх сараас 3-12 тохиолдлоор нэмэгдсэн бол бусад /зүрх судас, уушги судлал, ерөнхий мэс засал, эмэгтэйчүүд судлал, туяа эмчилгээ, толгой хүзүүний мэс засал/ кабинетуудын үйлчлүүлэгчийн хүлээгдэл 1-р сартай харьцуулахад 5-30 тохиолдлоор буурчээ.


ЭХЭМҮТ-ийн амбулаторын 3 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс нүдний кабинетэд 7 хоногоос дээш хугацаагаар 7 хүн бүртгэгдсэн нь өмнөх сарын түвшинд байна. Тус эмнэлгийн зүрх судас, мэдрэлийн тасаг тус бүр 1 хоногийн хүлээгдэлтэй 1,1 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УХТЭ-ийн хувьд амбулаторын 12 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэнээс уушги, бөөр судлалын тасагт тус бүр 7, зүрх судас, хоол боловсруулах, булчирхай судлал, мэдрэлийн тасагт тус бүр-6, мэс засал, чих хамар хоолойн тасагт тус бүр-5, уламжлалт эмчилгээний тасагт 3 үйлчлүүлэгч 1-3 хоногийн хүлээгдэлтэй байна.


Амбулаторын үзлэгийн хүлээгдлийг 1-р сарын хүлээгдэлтэй харьцуулахад УХТЭ-ийн бөөрний кабинет 1-р сард 34 үйлчлүүлэгч байсан бол 2-р сард 7, зүрх судасны кабинет 1-р сард 34, 2-р сард 6, уушгины кабинет 1-р сард 21, 2-р сард 7, мэс заслын кабинет 1-р сард 29, 2-р сард 5, мэдрэл судлал 1-р сард 38, 2-р сард 6, хоол боловсруулах эрхтэн судлал 1-р сард 41, 2-р сард 6 болсон бол ХСҮТ-ийн зүрх судасны кабинет 1-р сард 54, 2-р сард 24, мэс заслын кабинет 1-р сард 23, 2-р сард 8, эмэгтэйчүүд судлалын кабинет 1-р сард 60, 2-р сард 44, туяа эмчилгээ 1-р сард 18, 2-р сард 13, толгой хүзүүний мэс заслын кабинет 1-р сард 22, 2-р сард 15 болж хүлээгдэл буурсан байна.

ЭМС-ын 2017 оны А/48 тушаалаар амбулаторын зарим үзлэг, шинжилгээг 20 цаг хүртэл хийж гүйцэтгэх болсонтой холбогдуулан 2-р сард амбулаторын тусламж үйлчилгээний хүлээгдэл буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны 2-р сард УХТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын эмчийн үзлэгт хамрагдахаар хүлээж байгаа үйлчлүүлэгчийн тоо. /үзлэгийн кабинетийн төрлөөр/



УХТЭ, ХСҮТ-ийн 2017 оны 1 болон 2-р сарын амбулаторын зарим үзлэгийн хүлээгдлийн харьцуулалт.



Хоёр. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2017 оны 2-р сард 6 эмнэлэгт оношлогооны кабинетийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн оношлогооны кабинетүүдээс холтер хийлгэхээр 37 үйлчлүүлэгч 6 хоног, бүдүүн шулуун гэдэсний дуран хийлгэхээр 39 үйлчлүүлэгч 3 хоногийн хүлээгдэлтэй бүртгэгджээ. Дурангийн шинжилгээ хийлгэхээр 1-р сард 75 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн бол 2-р сард 39 болж 36 тохиолдлоор хүлээгдэл буурсан байна.

1-р сард УНТЭ-ийн MRI-35, захын судасны эхо-29, радио иммунологийн оношлогоо-128 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж байсан бол 2-р сард дээрх оношлогоонуудад хүлээгдэл огт бүртгэгдээгүй байна.


2-р сард УХТЭ-ийн рентген, нүдний уг дурандуулах, эхо, дурангийн тасаг 1-2 хоногийн хүлээгдэлтэй байлаа. Тус эмнэлгийн рентген оношлогоо 1-р сард 34 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байсан бол 2-р сард 49 болж 15 тохиолдлоор, эхо 7 тохиолдлоор өмнөх сараас нэмэгдсэн байна. Харин дурангийн шинжилгээ өмнөх сард 14 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байсан бол 2-р сард 9 болж, 5 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

УГТЭ-ийн рентген, доплерографи, эхо, хэвлийн дуран, тархины цахилгаан бичлэгийн оношлогоонд 3-6 хоногийн хүлээгдэл бүртгэгдсэн.

ХСҮТ-ийн хэвлийн эхо 6 хоног, ЭХЭМҮТ-ийн тархины цахилгаан бичлэг 1 хоногийн хүлээгдэлтэй байна. СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношлогоонд 101 үйлчлүүлэгч 1-15 хоног хүртэл хугацаагаар хүлээж үйлчлүүлсэн ба энэ нь өмнөх сарынхаас 79 тохиолдлоор буурсан байна.

ГССҮТ-ийн оношлогооны кабинет хүлээгдэлгүйгээр тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан байна.

УХТЭ-ийн оношлогооны кабинетийн 1, 2-р сарын хүлээгдлийн харьцуулалт:



Гурав. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторын шинжилгээний хүлээгдэл:

2017 оны 2-р сард лабораторын шинжилгээний хүлээгдэл 3 эмнэлэгт бүртгэгдсэн байна.

Биохимийн шинжилгээ УНТЭ-т 142 хүн 3 хоног, УХТЭ-т 105 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байгаа нь хамгийн олон үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй шинжилгээ байна.

УХТЭ-т цусны шинжилгээ 1-2 хоногийн хүлээгдэлтэй 13, бактериологи 1-2 хоногийн хүлээгдэлтэй 35, иммунологи 1 хоногийн хүлээгдэлтэй 5, серологийн шинжилгээ 1-2 хоногийн хүлээгдэлтэй 5 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УХТЭ-ийн бактериологийн шинжилгээ 1-р сард 25 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байсан бол 2-р сард 35 болж 10 тохиолдлоор нэмэгдсэн байна. Цус, биохими, иммунологийн шинжилгээ өгөх үйлчлүүлэгчийн хүлээгдлийн тоо өмнөх сараас буурсан хандлагатай байна.

УГТЭ-т 1-р сард цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ 7-14 хоногийн хүлээгдэлтэй байсан бол 2-р сард 1-3 хоногийн хүлээгдэлтэй болж буурсан.

Хүлээгдлийн мэдээ ирүүлсэн бусад /ЭХЭМҮТ, ХСҮТ, ГССҮТ, СЭМҮТ/ эрүүл мэндийн байгууллагуудын лабораторын тусламж үйлчилгээнд хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

Дөрөв. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2017 оны 2-р сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл УХТЭ-т 1-3 хоног, ЭХЭМҮТ-ийн эрсдэлтэй жирэмсэн, эмэгтэйчүүдийн эмгэгийн тасагт 1-3 хоног, УГТЭ-т 1-15 хоног, ГССҮТ-д 7 хоног, ХСҮТ-ийн элэг, цөс, нойр булчирхайн тасаг, хөнгөвчлөх эмчилгээ, хими эмчилгээний тасгуудад 1-15 хоног, СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиникт 1-30 хүртэл хоног, УАУТХ-д 1-30 хүртэл хоногийн хүлээгдэлтэй байна. УНТЭ хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй ажиллажээ.

УХТЭ-ийн бөөр судлал, зүрх судас, мэс засал, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн судлалын тасгуудын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл өмнөх сартай харьцуулахад 9-23 тохиолдлоор багасч, хүлээгдлийг бууруулан ажилласан байна.

УГТЭ-ийн зүрх судас, бөөр, нүд, чих хамар хоолой, элэг, цөс, нойр булчирхай, мэдрэлийн мэс заслын тасгийн 2-р сарын хэвтүүлэн эмчлэх хүлээгдлийг 1-р сартай харьцуулахад 7-21 тохиолдлоор буурсан байна. Харин уушгины тасгийн хүлээгдэл өмнөх сараас 4 тохиолдлоор нэмэгдсэн байна.


УАУТХ-д өмнөх сард хэвтэн эмчлүүлэх 246 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж байсан бол 2-р сард 61 болж 185 буюу 75,2%-иар үйлчлүүлэгчийн хүлээгдлийг бууруулсан байна.

ХСҮТ-ийн элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг 2-р сард 189 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байснаас 106 буюу 56% нь 1-3 хоног, 16,5% нь 3-6 хоног, 13,2% нь 15-30 хоногийн хүлээгдэлтэй байна. 1-р сард тус тасгийн хүлээгдэл 168 байсан ба 2-р сард хэвтэх хүлээгдэл 21 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн хүлээгдэл 43 байсан нь өмнөх сарын түвшинд байгаа ба эдгээрийн 18% нь 3-6 хоног, 44% нь 15-30 хоногоор тусламж үйлчилгээнд хамрагдахаар хүлээж байна. Туяа болон хими эмчилгээ, толгой хүзүүний мэс заслын тасгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас 1-22 тохиолдлоор нэмэгджээ.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасгийн хүлээгдэл 71 байгаа нь өмнөх сартай /121/ харьцуулахад 58,6%-иар буюу 50 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. 2-р сард тус тасагт хэвтүүлэн эмчлүүлэх хүлээгдэлтэй нийт үйлчлүүлэгчдийн 45% нь 15-30 хоног, 28% нь 1 сараас дээш хугацаагаар хүлээж байна. 1-р сард 15-30 хүртэл хоногоор 87 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байсан бол 2-р сард 32 болж 55 тохиолдлоор буурсан боловч 1 сараас дээш хугацаагаар хүлээж байгаа үйлчлүүлэгчийн тоо 1 сарынхаас 11 тохиолдлоор нэмэгдсэн байна.

1, 2-р сарын хэвтүүлэн эмчлэх хүлээгдлийг тасгаар харьцуулахад:



Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

СХД-ийн ЭМТ-ийн ахмадын тасаг 7 хоног, Хан-Уул дүүргийн ЭМТ-ийн дотрын тасаг 15 хоног, Налайх дүүргийн ЭМТ-ийн дотор, уламжлал, мэдрэлийн тасаг 7 хоног, Баянгол дүүргийн ЭМТ-ийн дотор, мэдрэлийн тасаг 7 хоног, наркологийн төв 7 хоногийн хүлээгдэлтэй, Чингэлтэй, Багануур дүүргийн ЭМТ,СХД, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгүүд хэвтүүлэн эмчлүүлэх хүлээгдэлгүй үйлчилсэн байна.

1-р сартай харьцуулахад хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл НЭМГ-ын харьяа байгууллагуудад буурсан байна.

Мэдрэлийн тасгийн хүлээгдэл СХД-ийн ЭМТ-д 14, НД-ийн ЭМТ 6, БГД-ийн ЭМТ-д нийт 25 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх сараас 9-30 тохиолдлоор буурсан бол ХУД-ийн ЭМТ-д 3 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Өмнөх сартай харьцуулахад дотрын тасгийн хүлээгдэл бүх дүүргийн эмнэлгүүдэд буурсан байна. СХД-ийн ЭМТ өмнөх сард 56 үйлчлүүлэгч 30 хүртэл хоногоор хүлээж байсан бол 2-р сард 2 үйлчлүүлэгч 3 хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна. ХУД-ийн ЭМТ-ийн дотрын тасгийн хүлээгдэл 1-р сард 74 байсан бол 2 сард 70 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байна. НД-ийн ЭМТ-ийн хүлээгдэл 6 болж өмнөх сараас 9 тохиолдлоор, БГД-ийн хүлээгдэл 42 болж өмнөх сараас 61 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.


Өмнөх сард ЧД-ийн ЭМТ-5, БЗД-ийн НЭ-12, ХУД-ийн НЭ-7 үйлчлүүлэгчийн хүлээгдэл байсан бол энэ сард тус тасгуудад хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

СХД-ийн ЭМТ-ийн ахмадын тасгийн хүлээгдэл 1-р сард 173 байсан бол 2-р сард 72 болж, 41,6%-иар буурчээ.


БНД-ийн ЭМТ-ийн хавдрын тасаг өмнөх сард хүлээгдэлгүй байсан боловч 2-р сард 6 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

Наркологийн эмнэлэгт 25 үйлчлүүлэгчийн хэвтүүлэн эмчлэх хүлээгдэл бүртгэгдсэнээс 15 тохиолдол буюу 60% нь 1-3 хоног, 30% нь 3-6 хоног, 8% нь 7-14 хоногийн хүлээгдэлтэй байна. Өмнөх сард тус тасаг 60 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байсан байна.


НЭМГ-ын харьяа нийт байгууллагуудын 2-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг 1-р сарын хүлээгдэлтэй харьцуулсан нь:



НЭМГ-ын харьяа зарим байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний 2017 оны 02-р сарын хүлээгдлийн мэдээ



СХД ЭМТ, ХУД ЭМТ, НД ЭМТ, БГД ЭМТ-ийн 2-р сарын дотор, мэдрэлийн тасгийн хүлээгдэл /хугацаагаар/




Нийслэлийн түргэн тусламжийн төвд 1-р сард 27531 дуудлага ирсэн бол 2-р сард 22.675 дуудлага ирж 4.856-аар дуудлага цөөрсөн байна. Нийт дуудлагын 31%-ийг 0-20 минутад, 34%-ийг 21-40 минутад, 20%-ийг 41-60 минутад, 14%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үзүүлсэн байна.

Өмнөх сард 0-20 минутад нийт ирсэн дуудлагын 27,2%, 21-40 минутад 30,5%, 41-60 минутад 18,6%, 1 цагаас дээш хугацаанд 23,7% хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 2-р сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 9,4%-иар буурч, хамгийн бага хугацаанд (0-20 минут) хүрч үйлчлэх тохиолдол 4,2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 1,2-р сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг харьцуулсан байдал



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЧАНАР, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АЛБА